

82

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлд:

“XVII.ХЭЛЭЛЦСЭН нь: Бусад асуудал

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан албан тушаалтанд даалгав:

1.Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

2.Замын хөдөлгөөний соёл, аюулгүй байдлыг хангуулах, энэ хүрээнд жолоочийн үүрэг, хариуцлагыг эрс нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, нийслэлийн Засаг даргад.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР